



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН СТАТИСТИК 2020



Улаанбаатар хот
2021 он

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Цэрэнхүүгийн Дулмаа

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч

ХЯНАСАН:

Батмөнхийн Батдаваа

ҮСХ-ны дарга

Чилхаасүрэнгийн Баянчимэг

ҮСХ-ны дэд дарга

Авирмэдийн Амарбал

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга

Ням-Очирын Должинсүрэн

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах статистикч

ИНФОГРАФИКИЙГ БЭЛТГЭСЭН:

Лувсандоржийн Хануй

ҮСХ-ны Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан

Санал, хүсэлтээ доорх хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын III байр

Бага тойруу - 44, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар -11, Монгол Улс

Утас : (976-51)-26-39-66

Факс : (976-11)-324518

Web хуудас : www.nso.mn, www.1212.mn

E-Mail : international@nso.mn; nso_hansg@nso.mn


Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, 2021 он

АГУУЛГА

ИНФОГРАФИК.....	4
БҮЛЭГ 1. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	6
1.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг.....	7
1.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг.....	8
1.3 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил.....	9
БҮЛЭГ 2. БҮРТГЭГДСЭН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ.....	12
2.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг.....	13
2.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч.....	14
2.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч.....	18
2.4 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг.....	19
2.5 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч.....	22
2.6 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч.....	23
2.7 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил.....	25
2.8 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хохирогч.....	28
2.9 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгч.....	28
ДҮГНЭЛТ.....	28
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	30


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг




Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч




Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн сэжигтэн холбогдогч




Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч



Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил



Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хохирогч





НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ, 2019-2020 он

Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн нийт 23.1 мянган хэргийн 1138 (4.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт (%)
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг	тоо	985	1 138	↑15.5
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	тоо	913	1 043	↑14.2
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	тоо	54	61	↑13.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч	тоо	894	1 082	↑21.0
Эмэгтэй	тоо	803	964	↑20.0
18 хүртэлх насны хүүхэд	тоо	66	91	↑37.9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч	тоо	850	1 015	↑ 19.4
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч	тоо	33	46	↑39.4
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч, хамаарлаар				
Эхнэр	тоо	484	562	↑16.1
Нөхөр	тоо	44	47	↑6.8
Хамтран амьдрагч	тоо	169	239	↑41.4
Төрсөн хүүхэд	тоо	36	44	↑22.2
Төрсөн эцэг, эх	тоо	37	25	↓32.4
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч	тоо	1 044	1 152	↑10.3
Эмэгтэй	тоо	76	94	↑23.7
18 хүртэлх насны хүүхэд	тоо	3	7	↑2.3дахин
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч, хамаарлаар				
Нөхөр	тоо	557	582	↑4.5
Хамтран амьдрагч	тоо	178	219	↑23.0
Хойд эцэг, эх	тоо	29	36	↑24.1
Эхнэр	тоо	24	32	↑33.3
Хүргэн, бэр	тоо	16	30	↑87.5
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч, боловсролын түвшнээр				
Боловсролгүй	тоо	54	56	↑3.7
Бага	тоо	105	86	↓ 18.1
Суурь	тоо	200	201	↑0.5
Бүрэн дунд	тоо	471	544	↑15.5
Дээд	тоо	173	224	↑29.5

1.2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, 2019-2020 он

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 111 (9.8%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн байна.

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт (%)
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	тоо	207	111	↓46.4
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар				
06-14 цаг	тоо	33	15	↓54.5
14-19 цаг	тоо	45	27	↓40.0
19-22 цаг	тоо	62	26	↓58.1
22-06 цаг	тоо	67	43	↓35.8
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн гарагаар				
Даваа	тоо	28	17	↓39.3
Мягмар	тоо	36	22	↓38.9
Лхагва	тоо	20	9	↓55.0
Пүрэв	тоо	35	21	↓40.0
Баасан	тоо	32	10	↓68.8
Бямба	тоо	19	12	↓36.8
Ням	тоо	37	20	↓45.9
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч	тоо	210	112	↓46.7
Хохирогч, хүйс, насны бүлгээр				
Эмэгтэй	тоо	196	97	↓50.5
18 хүртэлх насны	тоо	5	12	↑2.4 дахин
18-29 насны	тоо	42	31	↓26.2
30-39 насны	тоо	52	34	↓34.6
40-49 насны	тоо	59	18	↓69.5
50, түүнээс дээш насны	тоо	52	17	↓67.3
Хохирогч, боловсролын түвшнээр				
Боловсролгүй	тоо	4	5	↑25.0
Бага	тоо	8	10	↑25.0
Суурь	тоо	25	15	↓40.0
Бүрэн дунд	тоо	111	55	↓50.5
Тусгай дунд	тоо	12	5	↓58.3
Дээд	тоо	50	22	↓56.0
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч	тоо	172	84	↓51.2
Гэмт хэрэг үйлдэгч, хүйс, насны бүлгээр				
Эмэгтэй	тоо	6	4	↓33.3
18-29 насны	тоо	28	16	↓42.9
30-39 насны	тоо	60	35	↓41.7
40-49 насны	тоо	63	27	↓57.1
50, түүнээс дээш насны	тоо	21	6	↓71.4
Гэмт хэрэг үйлдэгч, хамаарлаар				
Нөхөр	тоо	118	40	↓66.1
Хамтран амьдрагч	тоо	20	15	↓25.0
Төрсөн хүү	тоо	12	-	
Төрсөн дүү	тоо	4	-	
Гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр				
Боловсролгүй	тоо	9	3	↓66.7
Бага	тоо	24	6	↓75.0
Суурь	тоо	35	16	↓54.3
Бүрэн дунд	тоо	75	39	↓48.0
Тусгай дунд	тоо	10	5	↓50.0
Дээд	тоо	19	15	↓21.1

1.3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧИЛ, 2019-2020 он

2020 онд бүртгэгдсэн нийт 2.3 сая зөрчлийн 10306 (0.5%) нь гэр бүлийн хүчирхийллийн зөрчил байна.

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт (%)
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил	тоо	8 962	10 306	↑ 15.0
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн заалтаар				
Мэдээлэх үүргээ биелүүлээгүй	тоо	135	114	↓15.5
Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн	тоо	6	2	↓66.6
Түр хамгаалах байрны кориулалтыг өөрчилсөн	тоо	1	1	
Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг				
Зодсон	тоо	6 089	7 917	↑30.0
Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан	тоо	2 453	1 890	↓23.0
Бусадтай харилцахыг хязгаарласан	тоо	34	35	↑2.9
Хуваарьт болон дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	тоо	244	347	↑42.2
Улаанбаатар хот	тоо	6 354	7 257	↑14.2
Орон нутаг	тоо	2 608	3 049	↑16.9
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, үйлдэгдсэн гарагаар	тоо			
Даваа	тоо	1 463	1 543	↑5.4
Мягмар	тоо	1 356	1 552	↑14.4
Лхагва	тоо	1 358	1 532	↑12.6
Пүрэв	тоо	1 258	1 471	↑16.9
Баасан	тоо	1 088	1 344	↑23.5
Бямба	тоо	1 140	1 401	↑22.8
Ням	тоо	1 299	1 463	↑12.6
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, үйлдэгдсэн цагаар	тоо			
06-12 цаг	тоо	685	805	↑17.5
13-18 цаг	тоо	1 698	1 869	↑10.1
19-24 цаг	тоо	5 787	6 674	↑15.3
01-05 цаг	тоо	792	958	↑20.9
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн хохирогч, хүйсээр	тоо	5 026	7 226	↑43.8
Эмэгтэй	тоо	4 613	6 645	↑44.0
Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгч, хамаарлаар	тоо	6 621	8 451	↑27.6
Нөхөр	тоо	3 844	4 781	↑24.4
Хамтран амьдрагч	тоо	1 067	1 486	↑39.3
Төрсөн эцэг	тоо	241	325	↑34.9
Төрсөн ах, эгч	тоо	124	146	↑17.7
Хойд эцэг, эх	тоо	95	101	↑6.3
Үрчилж авсан эх	тоо	2	-	
Хүргэн ах, дүү	тоо	8	12	↑50.0
Төрөл садан	тоо	30	36	↑20.0
Бусад	тоо	1 210	1 566	↑29.4

1.4 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ, 2019-2020 он



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 10 хэрэг тутмын

2019 онд

- 5 нь Улаанбаатар хотод
 - 4 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Сонгинохайрхан дүүрэгт

2020 онд

- 5 нь Улаанбаатар хотод
 - 4 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Сонгинохайрхан дүүрэгт



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч 100 хүн тутмын

2020 онд

- 94 нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч
- 4 нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч
- 1 нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч

2019 онд

- 95 нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч
- 4 нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч
- 1 нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч 100 хүн тутмын

- 8 нь 18 хүртэлх насны хүүхэд
- 37 нь 30-39 насных
- 27 нь 18-29 насных
- 18 нь 40-49 насныхан байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 100 хүн тутмын

- 45 нь бүрэн дунд боловсролтой
- 28 нь дээд боловсролтой хүн байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмаас хүчирхийлэлд өртсөн хүн

2020 онд

- 7 нь бие махбодийн хүчирхийлэлд
- 2 нь сэтгэл санааны хүчирхийлэлд

2019 онд

- 6 нь бие махбодийн хүчирхийлэлд
- 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч 100 хүн тутмын

2020 онд

- 52 нь эхнэр
- 22 нь хамтран амьдрагч
- 4 нь нөхөр

2019 онд

- 54 нь эхнэр
- 19 нь хамтран амьдрагч
- 5 нь нөхөр


1.5 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, 2019-2020 он

 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 100 хэрэг тутмын


- 2020 онд
 - 10 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн
- 2019 онд
 - 21 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн

 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 10 хэрэг тутмын


- 2020 онд
 - 6 нь Улаанбаатар хотод
 - 4 нь орон нутагт
- 2019 онд
 - 6 нь Улаанбаатар хотод
 - 4 нь орон нутагт

 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 100 хэрэг тутмын

- 2020 онд
 - 38 нь 22-06 цагт
 - 24 нь 14-19 цагт
 - 23 нь 19-22 цагт
- 2019 онд
 - 32 нь 22-06 цагт
 - 30 нь 19-22 цагт
 - 22 нь 14-19 цагт

 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 100 хохирогч тутмын

- 2020 онд
 - 11 нь 18 хүртэлх насны хүүхэд
 - 28 нь 18-29 насныхан
 - 30 нь 30-39 насныхан
 - 16 нь 40-49 насныхан байна.
- 2019 онд
 - 2 нь 18 хүртэлх насны хүүхэд
 - 20 нь 18-29 насныхан
 - 25 нь 30-39 насныхан
 - 28 нь 40-49 насныхан байна.

 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч 10 хүн тутмын

- 2020 онд
 - 5 нь нөхөр
 - 2 нь хамтран амьдрагч
- 2019 онд
 - 7 нь нөхөр
 - 1 нь хамтран амьдрагч

ХОЁРДУГААР БҮЛЭГ БҮРТГЭГДСЭНГЭРБҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ



2.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ, 2019-2020 он

Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн нийт 23.1 мянган хэргийн 1138 (4.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нь өмнөх оноос 1.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн байдлаар, 2015-2020 оноор

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020
Бүртгэгдсэн хэрэг-бүгд	27 757	27 167	32 259	36 220	31 524	23 064
Согтуугаар үйлдэгдсэн	5 907	5 520	4 012	3 289	4 371	4 855
Галт зэвсгээр үйлдсэн	38	33	44	39	36	40
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	1 356	1 449	1 286	1 069	985	1 138
Бүлэглэн гүйцэтгэсэн	2 274	1 635	1 829	1 714	1 805	1 482
Мансуурсан үедээ үйлдсэн	45	65	92	176	247	184
Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн	47	23	15	85	56	15

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг 2020 онд 1138 болж, өмнөх оноос 153-аар өсөхөд Улаанбаатар хот (90), Хөвсгөл (33), Баянхонгор (27), Төв (22), Ховд (17), Сүхбаатар аймгуудад (16)-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 584 (51.3%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг Баянзүрх (212), Сонгинохайрхан (116), Баянгол (72), Чингэлтэй (68) дүүргүүдэд хамгийн их бүртгэгджээ.

Хүснэгт 2.1.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, байршлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж байгууллага	Бусад газар
2019	985	839	65	27	1	2	2	49
2020	1 138	973	74	20	3	0	10	58
дүнд эзлэх хувь								
2019	100.0	85.2	6.6	2.7	0.1	0.2	0.2	5.0
2020	100.0	85.5	6.5	1.8	0.2	-	0.9	5.1

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 гэмт хэргийн 973 (85.5%) нь гэр, орон сууцанд, 74 (6.5%) нь гудамж, талбайд, 20 (1.8%) нь олон нийтийн газарт, 3 (0.2%) нь төрийн байгууллагад, 10 (0.9%) нь аж ахуй нэгж байгууллагад, 58 (5.1%) нь бусад газар үйлдэгдсэн нь өмнөх оноос гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 0.3 хувиар, аж ахуйн нэгж байгууллагад үйлдэгдсэн нь 0.7 хувиар, бусад газарт үйлдэгдсэн нь 1.0 хувиар, төрийн байгууллагад үйлдэгдсэн нь 0.2 хувиар өсөж, харин гудамж, талбайд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 0.1 хувиар, олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 0.9 хувиар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг өмнөх оноос өсөхөд гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 0.3 хувиар, аж ахуйн нэгж байгууллагад үйлдэгдсэн нь 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2.1.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар

Он	Улсын дүн	Гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	985	134	146	132	147	151	125	150	144	225	253	363
2020	1 138	170	179	146	167	163	127	186	191	283	244	420
дүнд харьцуулсан хувь												
2019	100.0	13.6	14.8	13.4	14.9	15.3	12.7	15.3	14.6	22.8	25.7	36.9
2020	100.0	15.0	15.7	12.8	14.7	14.3	11.2	16.3	16.8	24.9	21.4	36.9

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 170 нь даваа гарагт үйлдэгдэж өмнөх оноос 1.4 хувиар, ням гарагт үйлдэгдэж, 1.0 хувиар, мягмар гарагт үйлдэгдэж, 0.9 хувиар өсөж, харин бямба гарагт үйлдэгдэж, 1.5 хувиар, баасан гарагт үйлдэгдэж, 1.0 хувиар, лхагва гарагт үйлдэгдэж, 0.6 хувиар, пүрэв гарагт үйлдэгдэж, 0.2 хувиар тус тус буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 170 (15.0%) нь даваа гарагт, 179 (15.7%) нь мягмар гарагт, 146 (12.8%) лхагва гарагт, 167 (14.7%) нь пүрэв гарагт, 163 (14.3%) баасан гарагт, 127 (11.2%) нь бямба гарагт, 186 (16.3%) нь ням гарагт үйлдэгдсэн байна.

Хүснэгт 2.1.4 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг, гэмт хэргийн төрлөөр,
2016-2020 оноор

Гэмт хэргийн төрлөөр	2016	2017	2018	2019	2020
Улсын дүн	1449	1286	1070	985	1138
Хүний амьд явах эрхийн эсрэг	17	13	12	13	22
Хүнийг алах	16	12	7	12	21
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1	-	5	-	-
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	1356	1089	998	913	1043
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	-	198	210	207	111
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	33	166	47	54	61
Хүчиндэх	26	56	38	50	53
Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	-	-	2	-	1
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	-	-	5	2	2
Эрүүл мэндийн эсрэг	-	-	-	1	-
Хүүхдийн эсрэг	-	-	7	2	4
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	38	4	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	10	-	-	-
Бусад	1	4	1	-	6


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 1043 (91.6%) нь Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 61 (5.4%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 22 (1.9%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг байна.

2.2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ХЭРГИЙН ХОХИРОГЧ

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүн 2020 онд 1082 болж өмнөх оноос 188 (21.0%)-аар өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүний тоо өсөхөд Улаанбаатар хотод өмнөх оноос 130 (29.7%)-аар, Ховд аймагт 3.7 дахин, Баянхонгорт 3.1 дахин, Хөвсгөлд 2.9 дахин, Сүхбаатарт 2.4 дахин, Өмнөговьд 90.9%, Төв аймагт 80.8%-аар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


Харин Өвөрхангай 57.1 %, Дорнод 41.7%, Архангай 37.5%, Булган 36.8%, Хэнтий аймгуудад 27.3% -иар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч 1082 хүний 964 (89.1%) нь эмэгтэй хүн, 91 (8.4%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Зураг 2. 2.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч, 2019-2020 оноор



Улаанбаатар хотод гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч өмнөх оноос 130 (29.7%)-аар өсөхөд Чингэлтэй 42 (2.4 дахин), Сонгинохайрхан 28 (29.2%), Баянзүрх дүүрэгт 18 (9.7%)-аар өссөн голлон нөлөөлжээ (Зураг 2.2.2).


Зураг 2.2.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас Улаанбаатар хотод үйлдэгдсэн хэргийн хохирогч, дүүргээр, 2019-2020 оноор



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 1082 хүний 13 (1.2%) нь 7 хүртэлх насных, 78 (7.2%) нь 8-17 насных, 296 (27.4%) нь 18-29 насных, 396 (36.6%) нь 30-39 насных, 193 (17.8%) нь 40-49 насных, 74 (6.8%) нь 50-59 насных, 22 (2.0 %) нь 60-69 насных, 10 (0.9%) нь 70, түүнээс дээш насныхан байна (Зураг 2.2.3).


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 100 хүн тутмын 8 нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 27 нь 18-29 насных, 37 нь 30-39 насных, 18 нь 40-49 насныхан байна.

Зураг 2.2. 3 Хохирогч хүн, насны бүлгээр, хувиар, 2019-2020 оноор



Хохирсон 100 хүн тутмын 45 нь бүрэн дунд боловсролтой, 28 нь дээд боловсролтой хүн байна.

Зураг 2.2.4 Хохирогч хүн, боловсролын түвшнээр, хувиар, 2019-2020 оноор



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 1082 хүнийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 46.8% нь бүрэн дунд, 26.8% нь дээд, 12.5% нь суурь, 6.4% нь бага боловсролтой, 3.9% нь тусгай мэргэжлийн дунд, 3.5 % нь боловсролгүй хүн байна (Зураг 2.2.4).

2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүний 41.2%-ийг хамгаалалтанд авсан нь өмнөх оноос 0.6 пунктээр өссөн байна. 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 1082 хүний 784

(72.5%) нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн нь өмнөх оноос 9.3 %-иар өсөж, харин 196 (18.1%) нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж, 9.6%-иар буурсан байна.

Хүснэгт 2.2.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч, хамаарлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Эхнэр	Нөхөр	Хамтран амьдрагч	Төрсөн хүүхэд	Дагавар хүүхэд	Төрсөн эцэг, эх	Төрсөн дүү	Үрчилж авсан хүүхэд	Хадам эцэг, эх	Бусад
2019	894	484	44	169	36	27	37	10	2	9	76
2020	1 082	562	47	239	44	38	25	7	1	8	111
дүнд эзлэх хувь											
2019	100.0	54.1	4.9	18.9	4.0	3.0	4.1	1.1	0.2	1.0	8.7
2020	100.0	51.9	4.3	22.1	4.1	3.5	2.3	0.7	0.1	0.7	10.3

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 онд хохирсон 1082 хүний 562 (51.9%) нь эхнэр, өмнөх оноос 47 (4.3%) нь нөхөр, 239 (22.1%) нь хамтран амьдрагч, 44 (4.1%) нь төрсөн хүүхэд, 38 (3.5%) нь дагавар хүүхэд, 25 (2.3%) нь төрсөн эцэг эх, 7 (0.7%) нь төрсөн дүү, 1 (0.1%) үрчилж авсан хүүхэд, 8 (0.7%) нь хадам эцэг, эх, 111 (10.3%) нь бусад хүн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон эхнэр өмнөх оноос 2.2 хувиар, төрсөн эцэг, эх 1.8 хувиар, нөхөр 0.6 хувиар, төрсөн дүү 0.4 хувиар, хадам эцэг, эх 0.3 хувиар, үрчилж авсан хүүхэд 0.1 хувиар тус тус буурч, харин хамтран амьдрагч 3.2 хувиар, дагавар хүүхэд 0.5 хувиар, бусад 1.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.2.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн хохирогч, гэмт хэргийн төрлөөр, 2010-2020 оноор

Гэмт хэргийн төрлөөр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Улсын дүн	329	408	433	319	1 106	1 307	1 356	1 100	796	894	1 082
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	12	11	13	4	8	26	16	7	5	8	16
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	265	340	387	295	1 039	1 212	1 270	932	767	850	1015
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	-	-	-	1	-	-	-	2	1	1
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	27	20	13	21	33	34	151	21	33	46
Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	5	8	4	3	4	10	3	3	-	1	1
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	21	21	8	3	32	25	33	5	-	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	6	1	-	-	-	-	-	-	-	-	-
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	-	1	1	1	-	-	2	-	-	2
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	-	-	1	1	1

2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 гэмт хэргээс 1082 хүн хохирсны 1015 (93.8%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 46 (4.3%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 16 (1.5%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 1082 хүний 964 (89.1%) нь эмэгтэйчүүд, 91 (8.4%) нь хүүхэд байна (Хүснэгт 2.2.2).


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 онд учирсан хохирол 928.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 328.6 (54.8%) сая төгрөгөөр нэмэгдэж, харин төлүүлэлт хийгдээгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн

улмаас 2020 онд 18 хүн амь насаа алдсан нь өмнөх оноос 10 (2.3 дахин)-аар өссөн байна. Хүчирхийллийн улмаас амь насаа алдсан 18 хүний 11 (61.1%) эмэгтэйчүүд, 3 (16.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна. Амь насаа алдсан эмэгтэйчүүд 30-44 насныхан байна.

2.3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ

Улсын хэмжээгээр 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгч 1152 болж, өмнөх оноос 108 (10.3%)-аар өссөн байна. Гэмт хэрэг үйлдэгчийн тоо өмнөх оноос өсөхөд Улаанбаатар хот 106 (21.5%), Хөвсгөл 33 (3.1 дахин) өссөн нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн 735 (63.8%) согтуугаар хүчирхийлэл үйлддэг байна. Нийт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн 94 (8.2%) эмэгтэй, 7 (0.6%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Зураг 2.3.1 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч, насны ангиллаар, 2019-2020 оноор




Нийт 1152 гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт холбогдогчийн 507 (44.0%) нь 30-39 насных, 271 (23.5%) нь 40-49 насных, 255 (22.2%) нь 18-29 насных, 100 (8.7%) нь 50-59 насных, 12 (1.0%) нь 60, түүнээс дээш насных, 7 (0.6%) нь 14-17 насныхан байна (Зураг 2.3.1).

Бүрэн дунд боловсролтой гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт холбогдогч 2020 онд 544 болж, өмнөх оноос 73-аар, дээд боловсролтой 224 болж, 51-ээр өсч, харин бага боловсролтой 86 болж, 19-өөр буурсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь бүрэн дунд, дээд, суурь боловсролтой иргэд байна (Зураг 2.3.2).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч 10 хүн тутмын 5 нь бүрэн дунд боловсролтой, 2 нь суурь боловсролтой, 10 нь эрэгтэй хүн, 5 нь нөхөр нь байна.

Зураг 2.3.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч, боловсролын түвшнээр, 2019-2020 оноор



Хүснэгт 2.3.1 Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт холбогдогч, хамаарлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Нөхөр	Эхнэр	Төрсөн эцэг, эх	Хамтран амьдрагч	Төрсөн хүү	Төрсөн ах, эгч	Хадам эцэг, эх	Төрсөн дүү	Хойд эцэг, эх	Хүргэн, бэр	Төрөл, садан	Бусад
2019	1 044	557	24	39	178	25	13	5	6	29	16	14	138
2020	1 152	582	32	46	219	6	12	6	6	36	30	14	163

Гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт холбогдогч нөхөр 2020 онд 582 болж, өмнөх оноос 25 (4.5%)-аар, эхнэр 32 болж, 8 (33.3%)-аар, төрсөн эцэг, эх 46 болж, 7 (17.9%)-гоор, хамтран амьдрагч 219 болж, 41 (23.0%)-ээр, хойд эцэг, эх 36 болж, 7 (24.1%)-гоор, хүргэн, бэр 30 болж, 14 (87.5%)-өөр нэмэгдэж, харин төрсөн хүү 6 болж, 19 (76.0%)-өөр, төрсөн ах, эгч 12 болж, 1 (7.7%)-ээр буурсан байна (Хүснэгт 2.3.1).

2.4 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 111 (9.8%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 100 хэрэг тутмын 10 хэрэгт эрүүгийн хэрэг (МУ-ын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)) үүсгэсэн байна.


Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 онд 111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 (46.4%)-гаар буурсан хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-ээр өссөн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 96-аар буурахад Улаанбаатар хотод 65-аар, Орхон аймагт 5-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

2020 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 111 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 65 (58.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 65 (50.0%)-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас 2020 онд 21 хүн амь насаа алдаж, МУ-ын ЭХ-ийн 10.1 (Хүнийг алах)-ээр зүйлчлэгдсэн нь өмнөх оноос 9 (75.0%)-өөр өссөн байна.

Зураг 2.4.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 2016-2020 оноор



Зураг 2.4.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг ба Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, 2020 оны сараар




Хүснэгт 2.4.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн гараг, цагаар, 2019-2020 он

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2020	111	17	22	9	21	10	12	20	15	27	26	43
2019	207	28	36	20	35	32	19	37	33	45	62	67
дүнд харьцуулсан хувь												
2020	100.0	15.3	19.8	8.1	18.9	9.0	10.8	18.0	13.5	24.3	23.4	38.7
2019	100.0	13.5	17.4	9.7	16.9	15.5	9.2	17.9	15.9	21.7	30.0	32.4

2020 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн 111 хэргийн 17 (15.3%) нь даваа гарагт, 22 (19.8%) нь мягмар гарагт, 9 (8.1%) нь лхагва гарагт, 21 (18.9%) нь пүрэв гарагт, 10 (9.0%) нь баасан гарагт, 12 (10.8%) нь бямба гарагт, 20 (18.0%) нь ням гарагт үйлдэгджээ. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн 111 хэргийн 43 (38.7%) нь 22-06 цагт, 26 (23.4%) нь 19-22 цагт, 27 (24.3%) нь 14-19 цагт, 15 (13.5%) нь 06-14 цагт үйлдэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 62.1 хувийг 19 цагаас өглөөний 6 цагийн хооронд үйлдэгдсэн байна (Хүснэгт 2.4.1).

Зураг 2.4.3 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2019-2020 оноор



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 111 гэмт хэргийн 186 (89.9%) нь гэр, орон сууцанд, 10 (4.8%) нь гудамж, талбайд, 6 (2.9%) нь олон нийтийн газар, 1 (0.5%) нь төрийн байгууллагад, 1 (0.5%) нь төрийн бус байгууллагад, 3 (1.4%) нь бусад газар үйлдэгдсэн өмнөх оноос гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 3.0 хувиар, бусад газарт 1.0 хувиар буурч, харин гудамж, талбайд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2.9 хувиар, олон нийтийн газарт 1.0 хувиар өссөн байна. 2020 онд үйлдэгдсэн 111 хэргийн 57 (51.4%) хэргийг согтуугаар үйлджээ (Хүснэгт 2.4.2).

Хүснэгт 2.4.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Гэр, орон сууц	Гудамж, талбай	Олон нийтийн газар	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад газар
2019	207	186	10	6	1	1	3
2020	111	104	1	-	1	-	5
дүнд эзлэх хувь							
2019	100.0	89.9	4.8	2.9	0.5	0.5	1.4
2020	100.0	93.7	0.9	-	0.9	-	4.5

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг 2020 онд 111 болж, өмнөх оноос 96-аар буурахад Улаанбаатар хотод 65-аар, Хэнтий аймагт 10-аар буурсан нь голлон нөлөөлөв. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 111 хэргийн 65 (58.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 111 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийн 57 (51.4%) хэргийг согтуугаар, 110 (99.1%) хэргийг санаатайгаар үйлджээ.


2.5 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч 2020 онд 210 болж өмнөх оноос 98 (46.7%)-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч өмнөх оноос буурахад 40-49 насныхан 41-ээр, 50-59 насныхан 20-оор, 30-39 насныхан 18-аар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 112 хохирогчийн 97 (86.6%) нь эмэгтэй хүн, 12 (10.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 111 гэмт хэргийн хохирогч 112 хүний 3 (2.7%) нь 7 хүртэлх насных, 9 (8.0%) нь 8-17 насных, 31 (27.7%) нь 18-29 насных, 34 (30.4%) нь 30-39 насных, 18 (16.1%) нь 40-49 насных, 7 (6.3%) нь 50-59 насных, 4 (3.6%) нь 60-69 насных, 6 (5.4%) нь 70, түүнээс дээш насныхан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болсон 100 хүн тутмын 11 нь 18 хүртэлх насны хүүхдүүд, 28 нь 18-29 насных, 16 нь 30-39 насныхан байна.

Зураг 2.5.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, насны бүлгээр, 2019-2020 оноор




Хүснэгт 2.5.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, хамаарлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, гарагаар							Цагаар			
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	06-14	14-19	19-22	22-06
2019	207	28	36	20	35	32	19	37	33	45	62	67
2020	111	17	22	9	21	10	12	20	15	27	26	43
дүнд харьцуулсан хувь												
2019	100.0	13.5	17.4	9.7	16.9	15.5	9.2	17.9	15.9	21.7	30.0	32.4
2020	100.0	15.3	19.8	8.1	18.9	9.0	10.8	18.0	13.5	24.3	23.4	38.7

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч эхнэр 2020 онд 51 болж, өмнөх оноос 25 (4.5%)-аар, хамтран амьдрагч 219 болж, 41 (23.0%)-ээр, хойд эцэг, эх 36 болж, 33 (12 дахин)-аар, хүргэн, бэр 30 болж, 14 (87.5%)-өөр нэмэгдэж, харин төрсөн хүү 6 болж, 19 (76.0%)-өөр, төрсөн ах, эгч 12 болж, 1 (7.7%)-ээр буурсан байна (Хүснэгт 2.5.1).

Зураг 2.5.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч, боловсролын түвшнээр, 2019-2020 оноор




Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч 112 хүний 55 (49.1%) нь бүрэн дунд боловсролтой, 22 (19.6%) нь дээд боловсролтой, 15 (13.4%) нь суурь боловсролтой, 10 (8.9%) нь бага боловсролтой, 5 (4.5%) нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 5 (4.5%) нь боловсролгүй байна. Өмнөх оноос хохирсон боловсролгүй хүн 2.6 пунктээр, бага боловсролтой 5.1 пунктээр, суурь боловсролтой 1.5 пунктээр нэмэгдэж, харин бүрэн дунд боловсролтой хүн 3.8 пунктээр, тусгай дунд боловсролтой хүн 1.3 пунктээр, дээд боловсролтой хүн 4.2 пунктээр буурсан байна (Зураг 2.5.2).



2.6 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧ

Улсын хэмжээгээр 2020 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч 84 болж, өмнөх оноос 88 (51.2%)-аар буурсан байна. Гэмт хэрэг үйлдэгчийн тоо өмнөх оноос 88-аар буурахад 40-49 насных 36-аар, 30-39 насных 25-аар буурсан нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн 4 (4.8%) эмэгтэй хүн байна. Харин 18 -аас дээш насныхан гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг байна.


Зураг 2.6.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч, насны бүлгээр, 2019-2020 оноор



Нийт 84 хүчирхийлэл үйлдэгчийн 35 (41.7%) нь 30-39 насных, 27(32.1%) нь 40-49 насных, 16 (19.0%) нь 18-29 насных, 6 (7.1%) нь 50-59 насныхан байна (Зураг 2.6.1).

Гэмт хэрэг үйлдэгч 10 хүн тутмын 4 нь 30-39 насных, 3 нь 40-49 насных байна.

Зураг 2.6.2 Гэмт хэрэг үйлдэгч, боловсролын түвшнээр, 2019-2020 оноор



Бүрэн дунд боловсролтой гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 2020 онд 39 болж, өмнөх оноос 36 (48.0%)-гаар, суурь боловсролтой гэмт үйлдэгч 16 болж, 19 (54.3%)-өөр, бага боловсролтой 6 болж, 18 (75.0%)-аар, дээд боловсролтой 15 болж, 4 (21.1%)-өөр, боловсролгүй 3 болж, 6 (66.7%)-гаар, тусгай дунд 5 болж, 5 (50.0%)-аар буурсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдээс бүрэн дунд, дээд, суурь боловсролтой иргэд хүчирхийлэл их үйлддэг байна (Зураг 2.6.2).

Хүснэгт 2.6.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч, хамаарлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Нөхөр	Эхнэр	Төрсөн эцэг, эх	Хамтран амьдрагч	Төрсөн хүү	Төрсөн ах, эгч	Хадам эцэг, эх	Төрсөн дүү	Хойд эцэг	Хүргэн	Төрөл, садан	Бусад
2019	172	118	-	1	20	12	1	-	4	1	-	1	14
2020	84	40	-	7	15	-	3	1	-	2	2	6	8
Дүнд эзлэх хувь													
2019	100.0	68.6	-	0.6	11.6	7.0	0.6	-	2.3	0.6	-	0.6	8.1
2020	100.0	47.6	-	8.3	17.9	-	3.6	1.2	-	2.4	2.4	7.1	9.5

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэгч нөхөр 2020 онд 40 болж, өмнөх оноос 78 -аар, хамтран амьдрагч 15 болж, 5 - аар, төрсөн хүү 0 болж, 12-оор бүүрч, харин төрсөн ах, эгч 3 болж, 2 - оор, хойд эцэг 2 болж, 1-ээр, хүргэн 2 болж, 2 – оор өссөн байна (Хүснэгт 2.6.1).


2019 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэгчдийн 119 (69.2%) нь согтуугаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол харин 2020 онд 57 (67.9%) нь согтуугаар хүчирхийлэл үйлдэж, өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.

2.7 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧИЛ

2020 онд бүртгэгдсэн нийт 2.3 сая зөрчлийн 10306 (0.5%) нь гэр бүлийн хүчирхийллийн зөрчил байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 2020 онд 96 (46.4%)-гаар буурсан хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 1344 (15.0%)-өөр өссөн байна (Зураг 2.7.1).


Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос өсөхөд Улаанбаатар хот 905-аар, Хөвсгөл 101-ээр, Сүхбаатар аймагт 74-өөр, Хэнтий аймагт 60-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.7.1 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, сараар, 2019-2020 оноор




Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-ээр өсөхөд 3 дугаар сард 1032-оор, 4 дүгээр сард 220-оор, долдугаар сард 219-өөр, наймдугаар сард 229-өөр өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 2.7.1).

Зураг 2.7.2 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил ба Корона вирусын өвчлөлийн тоо, 2020 оны сараар



Монгол Улсад корона вирусын өвчлөл тархаж эхэлсэн 2020 оны 3 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 1220-д хүрсэн бол 4 дүгээр сараас эхлэн сар бүр буурсан байна. Хөл хорио тогтоосон 11-12 сард корона вирусын өвчлөлийн тоо өссөн хэдий ч бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчил сар бүр буурсан байна (Зураг 2.7.2).

Зураг 2.7.3 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил ба Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 2019-2020 оноор



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу 2020 онд шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн 97 (1.1%) нь мэдээлэх үүргээ биелүүлээгүй, 4 (0.04%) нь түр хамгаалах байрны журам зөрчиж, нэвтэрсэн, 2 (0.02%) нь түр хамгаалах байрны зориулалт өөрчилсөн, 6197 (73.3%) нь гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон, 1798 (21.3%) нь хүсэл зоригийнх эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 25 (0.3%) нь бусадтай харилцахыг хязгаарласан, 328 (3.9%) нь хуваарьт болон дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан байна (Хүснэгт 2.7.1).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-өөр, шийдвэрлэсэн зөрчил 1817 (27.4%)-гоор тус тус өссөн байна.


Хүснэгт 2.7.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар, 2019-2020 оноор

Үзүүлэлтүүд	2019	2020
Улсын дүн	8 962	10 306
Мэдээлэх үүргээ биелүүлээгүй	135	114
Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн	6	2
Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн	1	1
Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хохироосон	8 820	10 189
Зодсон	6 089	7 917
Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан	2 453	1 890
Бусадтай харилцахыг хязгаарласан	34	35
Хуваарьт болон дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	244	347

Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хохироосон зөрчил 10189-д хүрч, өмнөх оноос 1369 (15.5%)-өөр өсөхөд гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон зөрчил 1828 (30.0%)-аар, хуваарьт болон дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан зөрчил 103 (42.2%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 2.7.1).

2020 онд Улаанбаатар хотод гэр бүлийн хүчирхийллийн 7257 зөрчил бүртгэгдэж, өмнөх оноос 903 (14.2%)-аар, орон нутагт 3049 гэр бүлийн хүчирхийллийн зөрчил бүртгэгдэж, 441 (16.9%)-ээр өссөн байна.

Зураг 2.7.2 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, үйлдэгдсэн гарагаар, 2019-2020 оноор



2020 онд бүртгэгдсэн 10306 гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн 1543 (15.0%) нь даваа гарагт, 1552 (15.1%) нь мягмар гарагт, 1532 (14.9%) нь лхагва гарагт, 1471 (14.3%) нь пүрэв гарагт, 1344 (13.0%) нь баасан гарагт, 1401 (13.6%) нь бямба гарагт, 1463 (14.2%) нь ням гарагт үйлдэгджээ. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн 805 (7.8%) нь 06-12 цагт, 1869 (18.1%) нь 13-18 цагт, 6674 (64.8%) нь 19-24 цагт, 958 (20.9%) нь 01-05 цагт үйлдэгдсэн байна (Зураг 2.7.2).

2.8 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧЛИЙН ХОХИРОГЧ

2020 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн 10306 зөрчлийн улмаас 7226 хүн хохирчээ. Энэ нь өмнөх оноос 2200 (43.8%)-аар нэмэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн улмаас хохирсон 7226 хүний 6645 (92.0%) эмэгтэйчүүд байна.

2.9 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧИЛ ҮЙЛДЭГЧ

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгч нөхөр 2020 онд 4781 болж, өмнөх оноос 937(24.4%) -гоор, хамтран амьдрагч 1486 болж, 419(39.3%)- өөр, төрсөн эцэг 325 болж, 84 (34.9%)-өөр, төрсөн ах 135 болж, 22 (19.5%)-оор, хойд эцэг 98 болж, 9 (10.1%)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2.9.1 Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгч, хамаарлаар, 2019-2020 оноор

Он	Улсын дүн	Нөхөр	Төрсөн эцэг	Хамтран амьдрагч	Төрсөн ах, эгч	Хойд эцэг, эх	Хүргэн ах, дүү	Төрөл садан	Үрчилж авсан эх	Бусад
2019	6 621	3 844	241	1 067	124	95	8	30	2	1210
2020	8 451	4 781	325	1 486	146	101	12	36	-	1 564
дүнд эзлэх хувь										
2019	100.0	58.1	3.6	16.1	1.9	1.4	0.1	0.5	0.03	18.3
2020	100.0	56.6	3.8	17.6	1.7	1.2	0.1	0.4	-	18.5

ДУГНЭЛТ:

- Улсын хэмжээгээр 2020 онд бүртгэгдсэн нийт 23.1 мянган хэргийн 1138 (4.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нь өмнөх оноос 1.8 хувиар нэмэгдсэн байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 2020 онд 1138 болж, өмнөх оноос 153-аар өсөхөд Улаанбаатар хот (90), Хөвсгөл (33), Баянхонгор (27), Төв (22), Ховд (17), Сүхбаатар аймгуудад (16)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэргийн хохирогч 2020 онд 1082 болж, өмнөх оноос 188 (21.0%)-аар өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүний тоо өсөхөд Улаанбаатар хотод өмнөх оноос 130 (29.7%)-аар, Ховд аймагт 3.7 дахин, Баянхонгорт 3.1 дахин, Хөвсгөлд 2.9 дахин, Сүхбаатарт 2.4 дахин, Өмнөговьд 90.9%, Төв аймагт 80.8%-аар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
- Улсын хэмжээгээр 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдогч 1152 болж, өмнөх оноос 108 (10.3%)-аар өссөн байна. Хэрэгт холбогдогчийн тоо өмнөх оноос өсөхөд Улаанбаатар хот 106 (21.5%), Хөвсгөл 33 (3.1 дахин)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн учирсан хохирол 2020 онд 928.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 328.6 (54.8%) сая төгрөгөөр нэмэгдэж, харин төлүүлэлт хийгдээгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 онд 18 хүн амь насаа алдсан нь өмнөх оноос 10 (2.3 дахин)-аар өссөн байна. Хүчирхийллийн улмаас амь насаа алдсан 18 хүний 11 (61.1%) эмэгтэйчүүд, 3 (16.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1138 хэргийн 111 (9.8%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 онд 111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 (46.4%)-гаар буурсан хэдий ч гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-ээр өссөн байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг өмнөх оноос 96-аар буурахад, Улаанбаатар хотод 65-аар, Орхон аймагт 5-аар буурсан нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас 2020 онд 21 хүн амь насаа алдаж, МУ-ын ЭХ-ийн 10.1 (Хүнийг алах)-ээр зүйлчлэгдсэн нь өмнөх оноос 9 (75.0%)-өөр өссөн байна.

- 2020 онд бүртгэгдсэн нийт 2.3 сая зөрчлийн 10306 (0.5%) нь гэр бүлийн хүчирхийллийн зөрчил байна. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос өсөхөд Улаанбаатар хотод (905)-аар, Хөвсгөл аймагт (101)-ээр, Сүхбаатар аймагт (74)-өөр, Хэнтий аймагт (60)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хохироосон зөрчил 10189-д хүрч, өмнөх оноос 1369 (15.5%)-өөр өсөхөд гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон зөрчил 1828 (30.0%)-аар, хуваарьт болон дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан зөрчил 103 (42.2%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.
- Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх оноос 1344 (15.0%)-ээр өсөхөд 3 дугаар сард 1032-оор, 4 дүгээр сард 220-оор, долдугаар сард 219-өөр, наймдугаар сард 229-өөр өссөн нь голлон нөлөөлжээ. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил өмнөх онтой харьцуулахад өссөн хэдий ч сараар авч үзэхэд Монгол Улсад корона вирусын өвчлөл тархаж эхэлсэн 3 дугаар сараас эхлэн сар бүр буурсан байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн улмаас хохирсон 7226 хүний 6645 (92.0%) эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 112 хохирогчийн 97 (86.6%) нь эмэгтэйчүүд, 12 (10.7%) нь 18, хүртэлх насны хүүхдүүд байгаа нь хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах төрийн бодлого үгүйлэгдэж байгааг илэрхийлж байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ГБХТХ- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

МУ- Монгол Улс

ҮСХ- Үндэсний статистикийн хороо

ЭХ- Эрүүгийн хууль

ЭХХШХ- Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль

АШИГЛАСАН МАТЕРИАЛ**Хууль:**

1. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
3. Эрүүгийн хууль, 2017 он
4. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

Мэдээллийн эх үүсвэр:

1. Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн захиргааны статистикийн мэдээлэл
2. Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан -www.1212.mn цахим хуудас

**ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ гэж Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон байнга зодсон, харгис хэрцгий харьцаж, догшин авирласан, тарчлаасан хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэмт үйлдлүүдийг ойлгоно (МУ-ын ЭХХШХ).

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ гэж гэр бүлийн хүчирхийллийн үлмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие мах бод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг ойлгоно (МУ-ын ГБХТХ).

Үндэсний статистикийн хороо гэр бүлийн хүчирхийллийн статистикийн мэдээллийг одоогоор Цагдаагийн ерөнхий газрын бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн мэдээллээр цуглуулж, нийтэд тархаадаг.

..... о О о